Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.11.20-ний өдрийн 41 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Багш нарын арга зүй болон хөгжлийг дэмжин, хүүхдэд эерэг зан чанар, хандлагыг төлөвшүүлэх, сургалтын чанарт ахиц гаргах зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж багшийн хөгжлийн төвийг техник хэрэгслээр хангах
- Сургуулийн хамран сургалтыг 2 хувиар нэмэгдүүлэх, сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан сурагчдыг бүрэн хангах
- Багшийн ажлын үр дүн, мэдлэг, ур чадвар, сурган хүмүүжүүлэх үндсэн үйл ажиллагааг үндэслэн бодитой үнэлж урамшуулан ажиллах
- Насан туршийн боловсролын үйлчилгээний бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож, бүх насны хүн ам насан туршдаа суралцах чиглэлээр цахим контентыг хөгжүүлж эхлэх
- Сургалтын чанарт ахиц гаргах зорилгоор мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжсэн “Сайн багш”, “Хос бичигтэн”, “Баянхонгор Робокон” “Англи хэлтэй-Баянхонгор” Цахим Баянхонгор” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын шилэн дансны 1,2,3 дугаар улиралд хяналт хийгдсэн зөрчил илрээгүй байна.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 987263.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19745.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1539710.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 30794.2 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

**3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14819,9 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 131,038.0 | 125,599.1 | (5,439.0) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 3,076.8 | 11,995.0 | 8,918.2 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 127,961.3 | 113,604.1 | (14,357.2) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 6,655,499.5 | 6,448,318.7 | (207,180.9) |
| Үндсэн хөрөнгө | 7,105,367.0 | 7,123,771.4 | 18,404.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (449,867.5) | (675,452.8) | (225,585.3) |
| **Нийт хөрөнгө** | 6,786,537.6 | 6,573,917.8 | (212,619.8) |
| Өр төлбөр | - | 22,102.5 | 22,102.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 6,786,537.6 | 6,551,815.3 | (234,722.3) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 6,786,537.6 | 6,573,917.8 | (212,619.8) |

*Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авав/*

Авлага дансны үлдэгдэл 11995.0 мянган төгрөг болж 8918.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар "Дэвжих болор" ХХК-аас "Ухаалаг самбар" худалдан авахаар мөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 113604.1 мянган төгрөг болж 14357.2 мянган төгрөгөөр буурсан нь үдийн цайны материал 1253.3 мянга, хүнсний материал 1616.5 мянга, аж ахуйн материал 19919.9 мянга, түлш шатах тослох

материал 2184.6 мянга, барилгын засварын материал 2420.0 мянган төгрөгөөр тус тус буурч, эм боох материал 2113.2 мянга, бичиг хэргийн материал 183.0 мянга, бусад хангамжийн материал 10740.9 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7123771.4 мянган төгрөг болж 18404.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 14355.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдаж авсан, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4249.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.11.06-ны өдрийн 108 дугаар тогтоолоор ашиглалтгүй байсан 200.0 мянган төгрөгийн программ хангаж акталсан байна

Өр төлбөр дансны үлдэгдэл 22102.5 мянга өссөн нь "РМБ" ХХК-д өгөх халаалтын өглөгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Энэ нь 2020 оны 12 сард орон нутгийн санхүүжилтийг татсантай холбоотой халаалтын өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6551815.3 мянган төгрөг болж 234722.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн 234722.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний данс оны эхэнд 2284232.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант оны эцэст 2129263.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь 2015 онд акталсан хичээлийн 2 байр болон тавилга хэрэгслийн дахин үнэлгээний 143007.5 мянга, 2018 онд акталсан тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийн 1030.4 мянга, 2019 онд акталсан 11 жилийн сургуулийн хичээлийн байрны уурын зуух болон тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний 10931.1 мянга нийт 154969.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасаагүй байна

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1304987.8 мянган төгрөг болж өмнөх оноос 59221.4 мянган төгрөгөөр буюу 4,7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 59221.4 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь тусгай зориулалтын санхүүжилт 118193.9 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 16605.6 мянган төгрөгөөр нэмэгдэж үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 16815.6 мянга, орон нутгийн төсвөөс авах урсгал үйл ажиллагааны санхүүжилт 58741.4 мянган төгрөгөөр буурсан зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

Нийт зардал 1539710.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 176827.1 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамжийн материалын зардлууд, урсгал засварын зардал, бусад урсгал шилжүүлгийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр зардлыг 1476199.4 мянган төгрөгөөр тооцон, суралцагчдын тоог 656, ажиллагсдыг 65 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1112484.0 мянган төгрөгөөр бууруулж 1363715.4 мянган төгрөгөөр, суралцагчдын тоог 603, ажиллагсдыг 65 орон баталсан байна. Цалин, НДШ, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, хоол, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг бууруулан баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1363715.4 мянган төгрөгийг батлагдсанаас 3 удаагийн зохицуулалт хийж 711180.5 мянган төгрөгөөр хасаж 1292782,3 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 1054834,3 мянга, орон нутгийн төсвөөс 237948,0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1054586.9 мянган, орон нутгийн төсвөөс 212006.6 мянган төгрөгийн нийт 1232328,7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж 34264.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1232328,7 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 6764.7 мянга, тогтмол зардал 25941.4 мянга, хоол хүнсний зардал 17263.6 мянга, үдийн цайны зардлыг 10236.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хоол, үдийн цайны зардлыг хэмнэсэн нь “Ковид-19” цар тахлаас шалтгаалж сургуулийн үйл ажиллагааг түр хязгаарлалт хийсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт-2* Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр зориулалтаар /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 71802 | 1,292,782,300.00 | 1,232,328,727.00 | 60,453,573.00 | 95.3 |
| АРГА ХЭМЖЭЭ 80109 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 237,948,000.00 | 212,006,600.00 | 25,941,400.00 | 89.1 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 237,948,000.00 | 212,006,600.00 | 25,941,400.00 | 89.1 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 237,948,000.00 | 212,006,600.00 | 25,941,400.00 | 89.1 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 234,948,000.00 | 209,006,600.00 | 25,941,400.00 | 89.0 |
| Эд хогшил худалдан авах | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | - | 0.0 |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 | | | - | 0.0 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,592,800.00 | 11,592,800.00 | - | 100.0 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 11,592,800.00 | 11,592,800.00 | - | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,592,800.00 | 11,592,800.00 | - | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 11,592,800.00 | 11,592,800.00 | - | 100.0 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | - | 0.0 |
| АРГА ХЭМЖЭЭ 80801 | | | - | 0.0 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 25,536,900.00 | 15,300,400.00 | 10,236,500.00 | 59.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 25,536,900.00 | 15,300,400.00 | 10,236,500.00 | 59.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 25,536,900.00 | 15,300,400.00 | 10,236,500.00 | 59.9 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | - | 0.0 |
| АРГА ХЭМЖЭЭ 81806 | | | - | 0.0 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 131,346,200.00 | 113,218,029.00 | 18,128,171.00 | 86.2 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 131,346,200.00 | 113,218,029.00 | 18,128,171.00 | 86.2 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 131,346,200.00 | 113,218,029.00 | 18,128,171.00 | 86.2 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 67,128,000.00 | 66,263,379.00 | 864,621.00 | 98.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,062,400.00 | 9,062,400.00 | - | 100.0 |
| Хангамж бараа материалын зардал | 882,000.00 | 882,000.00 | - | 100.0 |
| Нормативт зардал | 53,139,800.00 | 35,876,250.00 | 17,263,550.00 | 67.5 |
| эд хогшил авах зардал | 1,134,000.00 | 1,134,000.00 | - | 100.0 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 81834 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 653,585,000.00 | 650,218,845.00 | 3,366,155.00 | 99.48 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 653,585,000.00 | 650,218,845.00 | 3,366,155.00 | 99.48 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 653,585,000.00 | 650,218,845.00 | 3,366,155.00 | 99.48 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 522,058,700.00 | 521,139,605.00 | 919,095.00 | 99.82 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 75,713,500.00 | 73,266,540.00 | 2,446,960.00 | 96.77 |
| Хангамж бараа материалын зардал | 7,543,400.00 | 7,543,300.00 | 100.00 | 100.00 |
| Нормативт зардал | 18,595,100.00 | 18,595,100.00 | - | 100.00 |
| эд хогшил авах зардал | 10,314,700.00 | 10,314,700.00 | - | 100.00 |
| Томилолт зочны зардал | 1,159,300.00 | 1,159,300.00 | - | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 1,638,800.00 | 1,638,800.00 | - | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 16,561,500.00 | 16,561,500.00 | - | 100.00 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 81834 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 223,183,900.00 | 220,737,550.00 | 2,446,350.00 | 98.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 223,183,900.00 | 220,737,550.00 | 2,446,350.00 | 98.9 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 223,183,900.00 | 220,737,550.00 | 2,446,350.00 | 98.9 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 190,391,800.00 | 187,945,450.00 | 2,446,350.00 | 98.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 15,702,800.00 | 15,702,800.00 | - | 100.0 |
| Хангамж бараа материалын зардал | 7,089,300.00 | 7,089,300.00 | - | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 81834 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,589,500.00 | 9,254,503.00 | 334,997.00 | 96.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 9,589,500.00 | 9,254,503.00 | 334,997.00 | 96.5 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,589,500.00 | 9,254,503.00 | 334,997.00 | 96.5 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 8,333,100.00 | 7,998,103.00 | 334,997.00 | 96.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,125,000.00 | 1,125,000.00 | - | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 131,400.00 | 131,400.00 | - | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 33150.9 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан.

Үүнээс Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 7491.5 мянган төгрөгийг зарцуулж тэтгэвэрт гарахад нь

олгох тэтгэмжийн зардалд үйлчлэгч П.Болормаа, М.Нарантуяа нарын тэтгэмжийн 25659.4 мянган төгрөгийг олгоогүйгээс буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 141 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 6 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 68831.0 мянган төгрөгийн хугацаа хоцроож байршуулсан байна.

*Хүснэгт-3*

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 90 | 6 | | |
| 6 | Нийт | 27 | 151 | 142 | 6 | 1 | 2 |

*Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/*

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 53414,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 17869,7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 15100,0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчил давтан гаргахгүй байх 20444.3 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн байна. Уг зөвлөмжийн биелэлтийг 2020.08.18-ны өдрийн 32 тоот албан бичгээр ирүүлснийг хэрэгжилтийг тооцсон ба төлбөрийн актаас 201.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

*Хүснэгт-4* /мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 17869.7 | 2 | 17668.3 | 1 | 201.0 | 98.8 |
| Албан шаардлага | 1 | 15100.0 | 1 | 15100.0 | | | |
| Зөвлөмж | 2 | 20444.3 | 2 | 20444.3 | | | |
| **Нийт дүн** | 2 | 53414.0 | 2 | 53212.6 | 1 | 201.0 | 99.6 |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 165007.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 154969.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 153.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 9885.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Оны эхэнд 2284232.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант оны эцэст 2129263.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2015 онд акталсан хичээлийн 2 байр болон тавилга хэрэгслийн дахин үнэлгээний 143007.5 мянга, 2018 онд акталсан тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийн 1030.4 мянга, 2019 онд акталсан 11 жилийн сургуулийн хичээлийн байрны уурын зуух болон тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний 10931.1 мянга нийт 154969.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 хавсралт Нягтлан бодох бүртгэлийн дансны заабрын 4.44. "Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн руу шилжүүлнэ." гэсэн заалт болон Оршин байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 154969.0 мянган төгрөгийг бууруулж санхүүгийн тайланд залруулга хийлээ.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 10038.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 153.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ Үүнд:

1. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас захирлын 2020.12.24-ний өдрийн А/35 дугаар тушаалаар түлшний хөнгөлөлт олгохдоо захирал Д.Уранчимэг өөртөө тушаал гаргаж 153,0 мянган төгрөг авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38.“төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; гэсэн заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 10009,3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал *данстай холбоотой асуудал*

*1.1 <u>Илрүүлэлт:</u>* "Дэвших болор" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалттай нийцэхгүй байна.

***1.2** <u>Эрсдэл:</u>* Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

***1.3** <u>Өгсөн зөвлөмж:</u>* Өмнөх оны авлагыг барагдуулах, нийлүүлэгч ААНБ-аас хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулан Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

*1.4 <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>:* Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. *Удирдлагын дээд болон дотоод хяналт:*

*2.1* <u>Илрүүлэлт</u>: Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 142 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 6 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 68831.0 мянган төгрөгийн хугацаа хоцроож байршуулсан байна.

<u>2.2 *Эрсдэл:*</u> Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

2.3 <u>*Өгсөн зөвлөмж*</u>: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

2.4 <u>*Байгууллагаас өгсөн хариу тайлбар*</u>: Зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Н.БҮНЧИНСҮРЭН 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.25

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: 2020.12.31 | Аудитын нэр: | **2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит** | Аудитын код: БНА-2021/92/СТА-ТШЗ |
|---|---|---|---|
| Шалгагдсан байгууллагын нэр: | | *Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль* | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сургуулийн төсөвт оны эцэст зохицуулалт хийлгэж "Дэвжих болор" ХХК-аас сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885.0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэж Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна. | 9885.0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Д.Уранчимэг Д.Баярмаа |
| 2 | Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас захирлын 2020.12.24-ний өдрийн А/35 дугаар тушаалаар түлшний хөнгөлөлт олгохдоо захирал Д.Уранчимэг өөртөө тушаал гаргаж 153,0 мянган төгрөг авсан байна. | 153.0 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Д.Уранчимэг Д.Баярмаа |
| 3 | Дахин үнэлгээний нэмэгдэл данснаас 2015 оноос хойш акталсан барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн дахин үнэлгээний нэмэгдлийг хасаагүй байна | 154969.0 | Санхүүгийн тайланд залруулах | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Д.Уранчимэг Д.Баярмаа |
| 4 | Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 142 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 6 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна | 0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Д.Уранчимэг Д.Баярмаа |
| | **ДҮН** | 165007.0 | | | |